

БАТЛАВ
ТӨВ АЙМГИЙН МӨНГӨНМОРЬТ
СУМЫН ЗАСАГ ДАРГА

Б.БАТЧИМЭГ

**ТӨВ АЙМГИЙН МӨНГӨНМОРЬТ СУМЫН ӨВ СОЁЛЫН
ХҮЗҮҮВЧТЭЙ ЦОМЦОГ ГЭР БАРИХ АЖЛЫН ДААЛГАВАР**

2024 оны 06 дугаар сарын 12

Дугаар

Төв аймаг

д/д	Ажлын нэр төрөл	Тайлбар
1.	Ажил гүйцэтгэх үндэслэл	<ul style="list-style-type: none">Соёлын өвийг хамгаалах тухай хуульСумын Иргэдийн Төлөөлөгчдийн 2023 оны 12-р сарын 18-ны өдрийн 05-р тогтоол
2.	Ажлын зорилго	Төв аймгийн Мөнгөнморьт суманд өв соёлын цомцог өргөөтэй болох шинээр гэр бүл болж буй залуучуудын гэрлэх ёслолыг бүртгэх, Сумын хэмжээнд сургалт мэдээллийн ажил хийх, өв соёлыг сурталчлан түгээн дэлгэрүүлэх чиглэлээр өсвөр үе, залуучуудын дунд олон талт арга хэмжээ зохион байгуулах.
3.	Хамрах хүрээ	Төв аймгийн Мөнгөнморьт сумын бүх иргэд, төсөвт байгууллагууд.
4.	Ажил гүйцэтгэх хугацаа	Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэн болгоно.
5.	Ажлын иж бүрдэл	<ol style="list-style-type: none">Өв соёлын хүзүүвчтэй цомцог өргөө барихЦомцог өргөөний ард хүзүүвчээр холбосон залгаа 6x8 хэмжээтэй байшин барихТайлан бичих, хүлээлгэн өгөх
6.	Техникийн шаардлага	Өв соёлын хүзүүвчтэй цомцог өргөө нь 4 хэсгээс бүрдэнэ. <ol style="list-style-type: none">Их гэр / өв соёлын өргөө /<ul style="list-style-type: none">Диаметр 9м*9м /суурь цутгамал/Талбайн хэмжээ 81м²Цомцог өргөөний их биеийг орчин үеийн технологиор үндэсний хэв маягаа хадгалсан бүхэлд нь төмөр карказаар хийх.Их гэр гадна талаасаа дээвэр туурга бүгдийг сэндвичэн хавтангаар хийх, дотор бүрээс эсгий стандартын дагуу хийсэн байх.Их гэр дотор талаасаа үндэсний хэв маягтай сүүлийн үеийн шинэ технологийн тооно, багана, хана, унь бүгд сийлбэртэй байхГэрийн шалыг барилгын стандартын дагуу цутгамалан шалтай сүүлийн үеийн шийдэлтэй зөөлөн резинен наадаг өнгөлөг гоёлын хулдаас дэвссэн байх.Цомцог өргөө нь хойд талдаа хүзүүвчрүү орох давхар дотогшоо онгойсон хавтастай модон хаалгатай байх.

- Урд талдаа гаднаас орох хаалга давхар хаалгатай байх. /гадна хаалга нь төмөр, дотор хаалга нь хоёр хавтастай дотогшоо онгойдог байх./
- Урд хаалганы баруун зүүн талд 2ш цонх хийх. /цонхны өргөн 1м 20см, өндөр нь их гэрийн ханын өндөрт тохирсон гаднаасаа гоёлын хамгаалалт иршотктой байх./
- Их гэрийн гадуур тойрсон сайн чанарын давхар хаяавчтай байх.
- Цомцог их гэрийн хойморт хүзүүвчны хаалгыг тагласан 3-4м-ийн өргөнтэй хана босгох өндөр нь их гэрийн ханатай чацуу байх.
- Ханыг гипсэн хавтангаар хийх үүдрүү харсан нүүрэн талд түмэн насан үргэлжилсэн хээтэй хулдаасан обой наасан байх.
- Хурлын зориулалттай голоороо нэг нугарч эвхэгддэг бөөрөнхий ширээ 8ш байх.
- Хурлын ширээнд тохирсон өндөртэй давхарлаж хурааж болох түшлэгтэй сандал 50ш байх.
- Цомцог их өргөөнд урд хаалганы хоёр талд босоо өлгүүр 2ш байршуулсан байх. /аль болох олон хувцас өлгөхөөр тооцох/
- Их гэрийн гаднаас зочин орох үүдэнд терраас хийх.
- Терраасыг модоор хийж төмрөн хагас дээвэртэй хийх хэмжээ урт1.5 өргөн 2м /8x8 харицаатай/

2. Хүзүүвч / өв соёлын өргөөг байшинтай холбох

- Хүзүүвчийг их гэрийн хойд хаалганаас 2м-н урттай өргөн нь 1м 20см-ийн коридортой хийх.
- Хүзүүвчны коридорт онгойхооргүй баруун зүүн талд жижиг ижил хэмжээтэй вакум цонхыг өндөрт тохирсон байдлаар 2ш хийсэн байх.
- Хүзүүвчны шалыг барилгын стандартад тохирсон цутгамлан сүүлийн үеийн шийдэлтэй сайн чанарын наадаг резинэн өнгөлөг хулдаастай байх.

3. Амралтын өрөө, бэлтгэлийн өрөө хойд талд нь склад барих сайдинггаар өнгөлөх / 8*8 хэмжээтэй/ суурь цутгамал

- Дээврийг шувуу нуруутай хийх таазны өндөр 2м 20см-аас багагүй байх.
- Дээврийн хоёр талын пронтоныг битүүлж, гадна талаас дотор талаас нь хөөс шахаж дулаалсан байх.
- Өргөтгөлийн дотор талыг склад, цай бэлтгэх өрөө, амралтын гэсэн гурван тасалгаатай хийх
- Тасалгаануудад 3ш модон хаалга хийх, цай бэлтгэх өрөөнд гадагш гарсан хаалга 1ш хийх
- Цай бэлтгэх өрөөний цонхонд уур гаргагч сэнс хийх
- Амралтын болон цай бэлтгэх өрөөнүүдэд тус бүр нэг нэг цонх гаргасан байх. 4. Гэрэлтүүлэг хийх.

		<ul style="list-style-type: none"> • Цомцог өргөөний тоононы хүрээтэй жишиж голд нь доош унжсан 81м2 харьцуулсан тод асахаар абжур хийсэн байх. • Их гэрийн унь, хана бүрийн зааган дээр урт нь 1м 20см-ээс багагүй өргөн нь 20см-ээс багагүй өдрийн гэрлийг байршуулж өгөх. • Цомцог их өргөө, амралт болон цай бэлтгэлийн өрөө, склад, хүзүүвчны коридорны бүх цахилгааны ил монтажыг барилгын стандартын дагуу хийж бүрэн хүлээлгэж өгөх. Разетка унтраалга өрөө бүрт шаардлагатай газарт байрлуулах • Гадна террасанд гэрэлтүүлэг гэрлэн чимэглэл хийх.
7.	Ажлын хяналт, шалгалт	Захирамжаар томилогдсон ажлын хэсэг уг ажлын гүйцэтгэлийн явцад тогтмол хяналт тавих
8.	Ажлын үр дүнг хүлээлгэн өгөх	Хөрөнгө оруулалтын ажлыг ажлын даалгаварт тусгасан бүх ажлыг хийж гүйцэтгэсний дараа Захиалагч талд хүлээлгэн өгөх.
9.	Захиалагч байгууллага	Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газар
10.	Гүйцэтгэгч байгууллага	Тендерээр шалгарна
11.	Санхүүжилт, эх үүсвэр	Төв аймгийн Мөнгөнморьт сумын Орон нутгийн хөгжлийн сан – 154.000.000 / Нэг зуун тавин дөрвөн сая төгрөг /
12.	Даалгаварт тусгагдаагүй ажил	Ажлын даалгаварт тусгагдаагүй ажлыг нэмэлт нөхцөлөөр гүйцэтгэнэ.
13.	Эдийн засгийн тооцоо	Төсвийг ESTIMATOR-PRO программ болон зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцоолох.

ХЯНАСАН: АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ

ЗДТГ-ЫН ДАРГА

ГИШҮҮД: ИТХ-ЫН ДАРГА

ЕБС-Н ЗАХИРАЛ

БГТХМЭРГЭЖИЛТЭН

ӨВ МЕНЕЖМЕНТ ХХК

ЦАХИЛГААНЧИН

Ж.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Б.БАТЧУЛУУН

Н.РЭНЦЭНДОРЖ

Б.АЛТАНГЭРЭЛ

Г.БААТАРЗОРИГ

Б.БУД

Б.Бүг

